3	Ердийн гишүүн	Бат-Өлзийн Сайнзаяа	Монгол Улсын Хөгжлийн банкны Төслийн санхүүжилтийн газрын захирал
4	Ердийн гишүүн	Мягмарын Мөнхбаатар	Азиа Дайверсифайд Рийл Эстэйт Фанд Нэг” ХХК-ийн зөвлөх
5	Ердийн гишүүн	Товуудоржийн Даваажав	Худалдаа хөгжлийн банкны Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
6	Ердийн гишүүн	Нямдоржийн Сэргэлэн	Худалдаа хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч
7	Ердийн гишүүн	Батцэнгэлийн Үүрцайхбаатар	Капитрон банкны Гүйцэтгэх захирал
8	Хараат бус гишүүн	Энхбаярын Шижир	Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн удирдагч
9	Хараат бус гишүүн	Амаржаргалын Анар	"Синержи Фанд" ХХК-ийн Гүйцэтгэх захирал



ТУЗ-ИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

№	ТУЗ-ийн хурлын мэдээлэл	Хурлын	Хурлын дундаж
		тоо	ирц
1	МИК Холдинг ХК-ийн хурал	6	72.15 %
2	“МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал	1	66.6 %
3	МИК ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн хурал	11	76.7 %
4	МИК Рийл Эстэйт ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал	1	66.6 %
5	Тусгай зориулалтын компанийн (ТЗК) хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	103	79 %

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ нь түүний охин компани болох “МИК ОССК” ХХК, “Протега Фөрст” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын бүрэн эрхийг, “МИК Рийл Эстэйт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг, “МИК ОССК” ХХК-ийн ТУЗ нь ТЗК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг дүрэмд заасны дагуу тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

“МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд: Санхүүгийн тайлан, Аудитын үйлчилгээний гэрээ байгуулах, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, компанийн Бизнес төлөвлөгөө батлах, олон улсын зах зээл дээр үнэт цаас гаргахтай холбоотой баталгаа гаргах.

“МИК ОССК” ХХК-ийн ТУЗ-ийн хурлаар ТЗК үүсгэн байгуулах, Үнэт цаасжуулалтын хэлцлийн нөхцөл тогтоох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах, олон улсын зах зээл дээр үнэт цаас гаргах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

“МИК ОССК” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлын төсвийг хэлэлцэн баталлаа.

“МИК Рийл Эстэйт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн гишүүн сонгох асуудлыг хэлэлцэн баталлаа.

ТЗК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, Компанийн дүрмийг шинэчилж батлах, Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.



ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

Санхүү, аудитын хороо	Бүрэлдэхүүн	Хурлын тоо	Хурлын дундаж ирц
	Хорооны дарга: Э.Шижир Гишүүд: Т.Даваажав, Ч.Хашчулуун, А.Анар,	4	75%
Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо	Хорооны дарга: Ч.Хашчулуун, Гишүүд: М.Мөнхбаатар, Ч.Хашчулуун А.Анар,	7	75%
Эрсдэлийн удирдлагын хороо	Хорооны дарга: А.Энхжин Гишүүд: Б.Сайнзаяа, Б.Үүрцайхбаатар, Н.Сэргэлэн,	3	83.3 %
Тогтвортой хөгжлийн хороо	Хорооны дарга: Н.Сэргэлэн Гишүүд: А.Энхжин Э.Шижир,	2	100%

ТУЗ-ийн дэргэд байнгын үйл ажиллагаатай (4) хороо үйл ажиллагаа явуулж байна. Хорооны гишүүдийг ТУЗ-ийн гишүүдийн дотроос, хорооны даргыг томилогдсон хорооны гишүүдийн дотроос дийлэнх олонхын саналаар ТУЗ-ийн шийдвэрээр томилж, чөлөөлөлдөг. Санхүү, аудитын хороо, Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны гишүүдийн дийлэнх олонх нь мөн дарга нар нь хараат бус гишүүн байдаг.

Санхүү аудитын хороо

ТУЗ-д удирдах чиглүүлэх болон хянан шалгах үүргээ үр ашигтай, бүтээлчээр хийж гүйцэтгэхэд туслах, компанийн санхүүгийн төсөв, тайланд хяналт тавих, хөндлөнгийн аудитортай харилцан ажиллах, дотоод аудитын бодлого, журам зэргийг хангах асуудлыг хариуцна.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

- Компанийн санхүүгийн төсөв, төлөвлөгөө,
- Дотоод аудитын ажлын хөтөлбөр, тайлан
- Улирлын санхүүгийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан
- Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох



Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ нь эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарт хяналт тавих, бизнесийн үйл ажиллагаанд тулгарч болзошгүй эрсдэлийг хянах, дүгнэх асуудлыг хариуцна.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

- Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн баримтлал,
- Эрсдэлийн удирдлагын тайлан
- Комплаесийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан.

Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллыг хороо

Компанийн засаглалын тогтолцоо, түүнд хамаарах санхүү, дотоод хяналттай холбоотой баримт бичгээс бусад бодлого, дүрэм журам, тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэлт, хэрэгжилтэд хяналт тавих асуудал, ТУЗ-ийн гишүүн, ГУ болон ТУЗ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг албан тушаалтныг сонгон шалгаруулах, тавигдах шаардлагыг тодорхойлох, нэр дэвшүүлэх, тэдгээртэй байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах, ТУЗ болон ГУ-ын үйл ажиллагааг үнэлэх ажлыг зохион байгуулах, асуудал, ТУЗ-ийн гишүүн, ГУ болон ТУЗ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг албан тушаалтанд олгох цалин, урамшууллын бодлого, түүний хэрэгжилтэд хяналт тавих, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох, компанийн хүний нөөцийн бодлого, урамшууллын системийг тодорхойлж үр дүнг үнэлэх зэргийг хариуцна.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

- ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт,
- ГУ-ын тайлан, цалин, урамшуулал, Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт,
- ТУЗ-ийн ажлын албаны тайлан
- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт
- ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшуулал

Тогтвортой хөгжлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх ТХХ нь компанийн тогтвортой хөгжлийн бодлого, стратеги болон зорилтуудыг тодорхойлж, тэдгээрийн гүйцэтгэлийг тогтмол сайжруулах, хэмжүүр үзүүлэлт, тайлагналд хяналт тавих асуудлыг хариуцна. Тогтвортой хөгжлийн хорооны хурлаар Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцтай танилцаж ажиллаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЦАЛИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин тогтмол болон нэмэгдэл цалингаас бүрддэг. Суурь цалин нь ТУЗ-ийн гишүүнээс томилогдон ажиллаж байгаагийн хувьд сар болгон олгогдох тогтмол цалин бөгөөд харин нэмэгдэл цалинг хуралд оролцсон оролцоо тус бүрээр тооцогдон улирал нэг удаа олгодог. Нэмэгдэл цалинг ТУЗ-өөс баталсан аргачлалын дагуу олгодог.

Зардлын төрөл	Давтамж	Хүний тоо	Үүнээс:			
			2023/05/01-2023/12/31		2024/01/01-2024/04/30	
			суурь	нэмэгдэл	суурь	нэмэгдэл
Цалин	12	9	50,400,000	36,000,000	25,200,000	18,000,000
ТУЗ-ийн гишүүн	12	9	50,400,000			
				36,000,000	25,200,000	18,000,000
НДШ	12	9	6,199,200	4,428,000	3,099,600	2,214,000
Нийт зардал	12	9	56,599,200	40,428,000	28,299,600	20,214,000

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний дагуу цалин урамшууллын хэмжээг ТУЗ-өөс тогтоодог. Жил нэг удаа Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-д ажлаа тайлагнан ажилладаг.

ТУЗ нь Компанийн ашигтай ажиллуулсан тухай жилийн компанийн ашигт ажиллагааны түвшин, компанийн үйл ажиллагааны өсөлт, төлөвшил, эрсдэлийг бууруулах талаах хийсэн ажил, хүрсэн үр дүн зэргийг нь харгалзан Гүйцэтгэх удирдлагад урамшуулал олгож болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ

Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээний журмын дагуу 2025 оны 25/13 дугаартай тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааг үнэлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэж, 2025.3.24-28 өдрийн хооронд үнэлгээ явууллаа. Үнэлгээг нарийвчилсан асуулгын хуудсуудаар цахимаар цуглуулж, зохион байгуулсан бөгөөд үнэлгээ 1-ээс 5 хүртэлх шатлалаар өгөгдсөн.

№	ТУЗ-ын үйл ажиллагааны үнэлгээ	Үнэлгээ	Стратеги, манлайллын чиглэлээр сайн үнэлгээтэй: ТУЗ компанийн стратеги тодорхойлох үүргээ үр дүнтэй гүйцэтгэж (4.55), компанийн хэтийн чиглэлийг ойлгож, тодорхойлох мэдээллийг авч чаддаг (4.36) нь урт хугацааны чиг баримжаатай, төлөвлөлттэй ажиллаж байгааг харуулж Тогтсон хурал, зохион байгуулалт, хэлэлцүүлгийн соёл төлөвшсөн: ТУЗ-ийн хурлууд тодорхой дэг журамтай зохион байгуулагдаж (4.55), хэлэлцэх асуудлаар гишүүд нээлттэй санал солилцдог (4.55) нь шийдвэр гаргах процесс ил тод, хамтын оролцоотой явагдаж
1	Ерөнхий үнэлгээ ба бүрэн эрхийн хэрэгжилт	4.31	
2	ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн	4.60	
3	ТУЗ-ийн үйл ажиллагаа	4.31	
4	ТУЗ-ийн үүрэг, хариуцлага	4.16	
	Нийт дундаж	4.35	

байгааг илтгэж байна.

Эрсдэл, сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, мэдрэмж сайн: ТУЗ-ийн гишүүд компанийн эрсдэлийн талаарх хариуцлагыг ойлгодог (4.54), сонирхлын зөрчлийн асуудлыг илэрхийлэх чадвартай (4.636) үнэлэгдсэн нь ёс зүйн болон эрх зүйн мэдлэг, ойлголт төлөвшсөн байдлыг харуулж байна.

2024 оны үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнгээс харахад дээрх чиглэлүүдэд өндөр үнэлгээ авсан нь ТУЗ-ийн сайн засаглал, төлөвшсөн менежмент, хариуцлагатай хандлагыг харуулж байна.

Мөн харьцангуй сул үнэлгээ авсан үнэлгээний шалгууруудад үндэслэн анхаарах шаардлагатай чиглэлийг тодорхойлж сайжруулах төлөвлөгөө гаргалаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцүүлэг

2024.12.26-ны өдөр Компанийн стратеги төлөвлөгөө болон өнөөгийн нөхцөл байдал, зах зээлийн төлөв байдал зэрэг асуудлаар хэлэлцүүлэх зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт зөвлөх Д.Байлхүү, Д.Болдбаатар, ТУЗ-ийн дарга Ч.Хашчулуун, Хараат бус гишүүн Э.Шижир, ТУЗ-ийн гишүүн А.Энхжин, Т.Даваажав нар оролцож санал бодлоо солилцлоо.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Компанийн хугацаат тайлан, тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл засаглалын баримт бичгийг СЗХ, МХБ, компанийн сайтаар дамжуулан холбогдох журамд заасан хугацаанд нийтэд мэдээлж компанийн ил тод байдлыг ханган ажиллаа. Мөн гаднын хөрөнгө оруулагчид хүргүүлдэг тайлангийн холбогдох мэдээллийг бэлтгэн холбогдох нэгжид хүргүүлээ.

СЗХ-оос шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хүрээнд тус кодексийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутам СЗХ, МХБ-д шинэчлэн хүргүүлж хянан баталгаажуулж засаглалын зэрэглэл тогтоолгон байна.



**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хамрах хугацаа: 2025.04.30 байдлаар

АГУУЛГА

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ _____	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН _____	4
ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН _____	5

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

“МИК Холдинг” ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/58 тоот тушаалаар батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу гаргасан.

Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна.

Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Үнэлгээний оноо

Асуулга тус бүрийн хувьд:

- Бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2;
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1;
- Үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулах бөгөөд түүнийгээ хувьд шилжүүлэн, үнэлгээг 0-100 хувиар тооцож гаргасан болно.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн компанийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Нэгдсэн дүнгээс харахад “МИК Холдинг” ХК-ийн засаглалын нэгдсэн үнэлгээ нь 100 хувьтай буюу засаглал хэвийн эрсдэлгүй түвшинд гэж үнэлэгдэж байна.

№	Зарчим	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6		100
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100
8	Компанийн соёл	6	6		100
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100
Нэгдсэн дүн		72	72		100.0

ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам тусгасан.	2	100
2	Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон “Залгамж халааны бодлого”-оор зохицуулдаг.	2	100
3	ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	2025.03.24-ны өдрийн ТУЗ-ийн 25/13 дугаартай тогтоолоор ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны хүрээнд үнэлгээг зохион байгуулсан. Тус үнэлгээний тайланг 2025.04.17-ны өдөр ТУЗ-д танилцуулж 2025.04.30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд үр дүнг танилцуулсан. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг Компанийн засаглалын тайлан хэлбэрээр жилийн үйл ажиллагааны тайлангийн хавсралт болгон компанийн цахим хуудаст байршуулсан.	2	100
4	Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрмээр ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний асуудлыг зохицуулдаг. “МИК Холдинг” ХК нь үйл ажиллагааны явцад шийдвэр гаргалтын бүхий л шатанд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг суулгаж, бүх төрлийн жендерт суурилсан ялгаварлан гадуурхалтаас ангид байх, оролцогч талуудын эрх	2	100

			ашгийг хүндэтгэсэн, хамтын ажиллагааг дэмжсэн, тэгш хүртээмжтэй харилцааг эрхэмлэх зарчмыг хэрэгжүүлнэ. Энэхүү зарчмыг ТУЗ-ийн 2024 оны 24/04 дугаартай тогтоолоор батлагдсан “Тогтвортой хөгжлийн бодлого” -д тусгасан.		
5	ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-с баталсан “ТУЗ-ийн гишүүдэд танилцуулга хийх журам”-д заасан агуулга, хэлбэрийн дагуу шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд гарын авлагыг бэлтгэн хүргүүлж, чиглүүлэх сургалтыг хийдэг. Мөн ТУЗ-с жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд сургалт, семинарын агуулгыг хамруулан баталдаг бөгөөд сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ТУЗ-ийн тайланд тусгадаг. ТУЗ-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тус онд ТУЗ-ийн сургалтыг 5 сард зохион байгуулахаар төлөвлөсөн. Үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025.02.03-ны өдөр Lkhagvamyadag@frc.mn хаягт хүргүүлсэн.	2	100
6	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүргийг ТУЗ-ийн ажлын алба хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд тус алба нь 1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, 1 хуульчааас бүрддэг. Мөн албаны ажилчдыг компанийн дотоод журмын дагуу сонгон шалгаруулж, ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-с томилох шийдвэрийг гаргадаг. Ажлын албаны ажилчдын шууд удирдлага нь ТУЗ-ийн дарга бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа, харилцааг ТУЗ-ий ажлын албаны журмаар зохицуулдаг.	2	100
ДҮН				12	100
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.					

7	ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжүүлсэн	“МИК Холдинг” ХК-ийн дүрэмд зааснаар компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх ба 3 нь хараат бус байхаар зохицуулсан.	2	100
8	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн	“ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм” -ээр Санхүү, аудитын хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг болон үйл ажиллагааг зохицуулдаг.	2	100
9	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн	“ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм”-д Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг болон үйл ажиллагааг зохицуулдаг. Тус хорооны бүрэлдэхүүнд дийлэнх олонх нь хараат бус гишүүн байдаг. Мөн ТУЗ-ийн гишүүдийн цалинг тооцон олгох аргачлалтай бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалингийн мэдээллийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн хавсралт болгон засаглалын тайланд тусгасан болно.	2	100
10	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-өөс “Залгамж халааны бодлого”-ыг баталсан бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо нь уг бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй ажилладаг.	2	100
11	ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрмээр зохицуулдаг.	2	100
ДҮН				10	100
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.					
12	ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр “Мэдээллийн ил тод байдлын бодлого” -г баталсан.	2	100

13	ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудасны “Хувьцаа эзэмшигчид” гэсэн хэсэгт засаглалын баримт бичгүүдийг файлаар оруулсан.	2	100
14	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жилийн үйл ажиллагааны тайлангийн Эрсдэлийн удирдлагын тогтолцоо хэсгээс үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлийн удирдлага, тэдгээрийн хүрээнд хийгдэж буй ажлын талаар мэдээллийг дэлгэрэнгүй авах боломжтой. • Жилийн үйл ажиллагааны тайлан • БОНЗ-ийн тайлан	2	100
ДҮН				6	100
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.					
15	ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрмээр зохицуулдаг.	2	100
16	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн санхүүгийн хөндлөнгийн аудитын компани болох “Эрнст энд Янг Аудит Монголия” ХХК нь аудитын дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн 2025.04.30-ны өдрийн ээлжит хуралд биечлэн танилцуулсан.	2	100
17	Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жилийн үйл ажиллагааны тайланд тусган олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	2	100
ДҮН				6	100
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.					
18	Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн Гүйцэтгэх захирлын дэргэд Эрсдэлийн удирдлагын газар үйл ажиллагаа явуулж байна. Олон улсын санхүүгийн корпорацын (IFC) засаглалыг сайжруулах зөвлөмж, Компанийн засаглалын кодекст үндэслэн 2021 онд компанийн Эрсдэлийн удирдлагын	2	100

			бодлогыг ТУЗ-өөс шинэчлэл, 2022 онд Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн баримтлалыг ТУЗ-өөс тус тус баталсан. Дээрх баримт бичгийн хүрэн Гүйцэтгэх захирлын тушаалаар бусад холбогдох журмуудыг баталсан. Эрсдэлийн удирдлагын тайланг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган ажиллаж байна. Мөн жилийн үйл ажиллагааны тайланд Эрсдэлийн үйл ажиллагааны тайланг тусгасан. • Эрсдэлийн удирдлагын бодлого • ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм • Групп компанийн бүтэц		
19	ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо 4 бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Жилийн үйл ажиллагааны тайланд тус мэдээллийг тусгаж компанийн сайтад нийтлэн ажиллаж байна. • ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм	2	100
20	Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн	2022 оны Байгаль орчин, нийгэм засаглалын тайланг гарган Материаллаг байдлын үнэлгээ хийсэн. Мөн компанийн сайтад Тогтвортой хөгжил булан нээж мэдээллийг тогтмол хүргэж байна. ТУЗ-ийн дэргэд байнгыг үйл ажиллагаатай “Тогтвортой хөгжлийн хороо”-г шинээр байгууллаа. • БОНЗ-ын тайлан 2024 • Материаллаг байдлын үнэлгээ • Тогтвортой хөгжил булан	2	100
21	Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн Гүйцэтгэх захирлын дэргэд Комплаенсийн газар үйл ажиллагаа явуулж байна.	2	100

	хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.		Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2018 онд Комлаенсийн бодлогыг баталж байсан бөгөөд Олон улсын санхүүгийн корпорацын (IFC) засаглалыг сайжруулах зөвлөмж, Компанийн засаглалын кодекст үндэслэн сайжруулалт хийн 2021 онд дахин тус бодлогын баталсан. Комплаенсийн үйл ажиллагааны тайланг хагас жил тутам ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган ажиллаж байна. Мөн жилийн үйл ажиллагааны тайланд Комлаенсийн үйл ажиллагааны тайланг тусгасан. • Комплаенсийн бодлого • ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм • Групп компанийн бүтэц		
ДҮН				8	100
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	“МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар жил бүр ТУЗ-ийн гишүүдийн цалингийн төсөв баталдаг.	2	100
23	Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Гүйцэтгэх захирлын тушаалаар 2022 оны 5 дугаар сарын 30 өдөр Цалин, хөлсний журмыг батлан мөрдөн ажиллаж байна. Уг журмаар компанийн ажилтнуудын цалин, хөлсийг холдогдох хууль, журмын дагуу тооцон олгох, ажлын байрны түвшин тогтоох, түүнд тохирсон цалин, хөлс олгох харилцааг зохицуулж байна. Мөн Гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг баталсан. Уг журмаар ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийх зохицуулалтууд туссан. • ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм	2	100
24	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	“ ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм ”-д Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны чиг үүрэг, хэлэлцэх асуудлын жагсаалтыг тусгасан байдаг.	2	100

			Гүйцэтгэх захирлын тушаалаар 2022 оны 5 дугаар сарын 30 өдөр “Цалин, хөлсний журам”-ыг батлан мөрдөн ажиллаж байна. Уг журмаар компанийн ажилтнуудын цалин, хөлсийг холдогдох хууль, журмын дагуу тооцон олгох, ажлын байрны түвшин тогтоох, түүнд тохирсон цалин, хөлс олгох харилцааг зохицуулж байна. Мөн Гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг баталсан. Уг журмаар ажилтны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийх зохицуулалтууд туссан.		
ДҮН				6	100
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь оролцогч талуудын эрх ашгийг ханган ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. ТУЗ-өөс батлагдсан Ёс зүйн дүрэмд энэ талаар тусгасан.	2	100
26	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Мэдээллийн ил тод байдлын бодлого	2	100
27	Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна. Мөн компанийн сайтыг тогтмол хөтлөн шинэчлэн ажиллаж байна.	2	100
28	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	“ Ёс зүйн дүрэм ” болон “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгасан.	2	100
ДҮН				8	100
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					

29	Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн удирдах зөвлөлөөс “ Ёс зүйн дүрэм ”-ийг баталсан.	2	100
30	Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүтэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-өөс баталсан “ Ёс зүйн дүрэм ”-д заасны дагуу Эрх бүхий албан тушаалтны ёс зүйн зөрчлийг ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороогоор хэлэлцэхээр зохицуулсан.	2	100
31	Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-өөс баталсан “ Ёс зүйн дүрэм ”-д “Авлига, хээл хахуулаас ангид байх зарчим”-ыг тусгайлан тусгасан.	2	100
ДҮН				6	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-өөс баталсан “ Мэдээллийн ил тод байдлын бодлого ”-ыг ханган ажиллаж, оролцогч талуудад хүргэх хугацаат болон тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг МХБ болон компанийн веб хуудсаар дамжуулан мэдээлдэг.	2	100
33	Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн веб хуудас -т хөрөнгө оруулагчдад зориулсан тусгайлсан булан ажиллуулж санал хүсэлт хүлээн авдаг.	2	100
34	Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль болон бусад дүрэм журмаар тогтоосон журмын дагуу жил бүр зохион байгуулдаг. Хувьцаа эзэмшигчдийн үйлчлүүлж буй	2	100
35	Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн	үнэт цаасны компаниудад хурлын материалыг хэвлэмэл болон цахимаар жил болгон хүргүүлдэг. Мөн компанийн байранд ирж санал өгөх болон мэдээллээр ханган ажиллаж байна.	2	100
36	Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн мэдээллийн компанийн хагас жилийн, жилийн үйл ажиллагааны тайланд тусган	2	100

		хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлдэг.		
ДҮН			10	100
НЭГДСЭН ДҮН			72	100.0